

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын
улсын бүртгэл хөтлөх журам батлах тухай**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.2, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар /Б.Баасандорж/-т үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Билгүүн/-д даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2015 оны “Журам батлах тухай” А/39, А/40 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ журмыг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНИЙ САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газар, гадаадын хуулийн этгээд /компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газрыг шинээр үүсгэн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлт, хуулийн этгээдийг өөрчлөн байгуулсныг хуулийн этгээдийн улсын бүртгэл /цаашид “улсын бүртгэл” гэх/-д хөтлөхөд энэ журмыг баримтална.

1.2.Улсын бүртгэлийн байгууллага Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газар, мөн зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан гадаадын хуулийн этгээд /компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэнэ.

1.3.Олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж бүртгэнэ.

1.4.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг тухайн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийг харьяалах улсын бүртгэлийн байгууллагад бүртгэнэ.

/Энэ заалтыг 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

Хоёр.Улсын бүртгэл хөтлөх

2.1.Улсын бүртгэлийн байгууллага улсын бүртгэл хөтлөхөд дараах дарааллыг баримтална:

2.1.1.улсын бүртгэгч өргөдөл гаргагчаас цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг нягталж, хүлээн авах;

2.1.2.хүлээн авсан өргөдөл, баримт бичгийг улсын ахлах бүртгэгч улсын бүртгэгчид хуваарилах;

2.1.3.улсын бүртгэгч шаардлагатай тохиолдолд өргөдөл, баримт бичгийн үнэн зөвийг нотлох баримтыг холбогдох иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах;

2.1.4.улсын бүртгэгч шаардлагатай тохиолдолд баримт бичгийг эх хувиас хуулбарлан авч болох бөгөөд хуулбарт “Эх хувиас хуулбарлав” тэмдэг дарж хувийн хэрэгт хавсаргах;

2.1.5.улсын бүртгэгч улсын бүртгэлийн мэдээллийн сангаас тухайн бүртгэл хөтлөхөд шаардагдах мэдээллийг нягтлан шалгаж, холбогдох лавлагаа, баримтыг хэвлэн хувийн дугаар бүхий тэмдгээр баталгаажуулж, хуульд заасны дагуу бүрдүүлэх, баримт бичигт хавсаргах;

2.1.6.иргэн, хуулийн этгээд цаасан хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэгч өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн бүрдэл, мэдээллийг хянаж, шийдвэр гаргах;

2.1.7.иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлд бүртгэх эсэх хариу мэдэгдлийг өргөдөл гаргагчид илгээх, улсын бүртгэлд бүртгэх мэдэгдэл хүлээн авсан өргөдөл гаргагч өргөдөл, баримт бичгийн эх хувийг улсын бүртгэлийн байгууллагад ирүүлэх;

2.1.8.улсын бүртгэгч тухайн хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтлөх;

2.1.9.улсын бүртгэгч хуулийн этгээдийн дүрэм /гэрээ/-ийн эхний хуудасны баруун дээд хэсэгт баталгааны тэмдэг, бусад хуудасны баруун доод хэсэгт улсын бүртгэгчийн тэмдэг дарах;

2.1.10.улсын бүртгэлийн байгууллага улсын бүртгэлийн цахим гэрчилгээг өргөдөл гаргагч хэвлэн авах боломжтойгоор улсын бүртгэлийн мэдээллийн санд байршуулж болох бөгөөд өргөдөл гаргагчийн хүсэлтээр улсын бүртгэлийн гэрчилгээг хэвлэж, баталгаажуулах;

2.1.11.баталгаажуулсан болон хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг тусгасан улсын бүртгэлийн гэрчилгээг улсын бүртгэгч хуулбарлаж, хувийн хэрэгт хавсаргах.

2.2.Улсын бүртгэгч өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт, хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлд бүртгэхэд өргөдөл гаргагчаас ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг хуулийн этгээдийн цахим хувийн хэрэгтэй, шаардлагатай бол архивын эх нотлох баримттай тулган нягталж, бүртгэх эсэх шийдвэр гаргана.

2.3.Улсын бүртгэгч улсын бүртгэлд бүртгэгдсэн баримт бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээг баримт бичиг олгох ажилтанд, тухайн хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлнэ.

2.4.Улсын бүртгэгч улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэр, баримт бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээг баримт бичиг олгох ажилтанд шилжүүлнэ.

2.5.Баримт бичиг олгох ажилтан энэ журмын 2.3, 2.4-т заасны дагуу шилжүүлсэн баримт бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээг олгохдоо тэмдэглэл үйлдэнэ.

Гурав.Улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргах

3.1.Улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан этгээд гаргана.

3.2.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ журмын 7, 8, 9, 10 дугаар зүйлд заасан улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл эрх бүхий этгээдийн тамга, тэмдэг, гарын үсгээр баталгаажсан байна.

3.3.Өргөдөлд хавсаргасан баримт бичиг гадаад хэлээр үйлдэгдсэн бол Монгол хэлнээ орчуулж, баталгаажуулсан хувийг хавсаргана.

3.4.Өргөдөлд хавсаргасан баримт бичиг гадаад улсад үйлдэгдсэн бол апостиль, нотариатч, эсхүл консулаар гэрчлүүлсэн байна.

3.5.Өргөдөл гаргагч Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасны дагуу шинээр болон өөрчлөн байгуулах хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулснаас хойш 30 хоногийн дотор, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг ажлын 15 өдрийн дотор бүртгүүлэх өргөдлийг улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

Дөрөв.Улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл хүлээн авах

4.1.Улсын бүртгэгч Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээдийн мөн хуулийн 14-16, 19, 20, 22, 24 дүгээр зүйлд заасан өргөдөл, баримт бичгийг хянаж, холбогдох хууль, журамд заасан шаардлага хангасан бол хүлээн авч, хуудсыг дугаарлан, хүлээн авсан тухай хуудсыг өргөдөл гаргагчид өгч, улсын бүртгэлд бүртгэх эсэхийг ажлын 2 өдрийн дотор шийдвэрлэнэ.

4.2.Иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэгч өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн бүрдэл, мэдээллийг хянаж, хуульд заасан шаардлага хангасан бол улсын бүртгэлд бүртгэх боломжтой талаарх мэдэгдлийг ажлын 2 өдрийн дотор илгээж, уг мэдэгдлийг хүлээн авсан иргэн, хуулийн этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан өргөдөл, баримт бичгийн эх хувийг ажлын 5 өдрийн дотор ирүүлж бүртгүүлнэ.

Тав.Улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг хүлээн авахаас татгалзах

5.1.Улсын бүртгэгч дараах тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, буцаана:

5.1.1.улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийн шаардлага хангаагүй, бүрдэл дутуу;

5.1.2.энэ журмын 3.1-д зааснаас бусад этгээд өргөдөл гаргасан;

5.1.3.энэ журмын 5.2-т заасны дагуу өргөдөл дахин гаргах эрх үүсээгүй.

5.2.Өргөдөл гаргагч улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг дараах үндэслэл арилсан тохиолдолд дахин гаргаж болно:

5.2.1.энэ журмын 11-т заасны дагуу улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан;

5.2.2.хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, эрх бүхий хууль хяналтын байгууллагын шийдвэрээр бүртгэлийг хүчингүй болгосон;

5.2.3.энэ журмын 12-т заасны дагуу улсын бүртгэлд хориг тавьсан /түдгэлзүүлсэн/.

Зургаа.Шинээр байгуулсан хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх

6.1.Шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасныг баримтална.

6.2.Шинээр байгуулсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлэн, өргөдөлд хавсаргана:

6.2.1.хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт;

6.2.2.үүсгэн байгуулах баримт бичиг буюу хуулийн этгээд байгуулсан шийдвэр /тогтоол/, дүрэм, хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээ;

6.2.3.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

6.2.4.улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт;

6.2.5.хувь нийлүүлсэн хөрөнгөтэй тохиолдолд холбогдох нотлох баримт;

6.2.6.хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт;

6.2.7.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, удирдах зөвлөл, эрх бүхий этгээд гадаадын иргэн бол паспортын хуулбар;

6.2.8.хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрөл.

6.3.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь хэсэгт заасны дагуу дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

6.3.1.гадаадын төрийн өмчит хуулийн этгээд үүсгэн байгуулагчаар бүртгүүлэх бол гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий этгээдийн шийдвэр;

6.3.2.хоёр буюу түүнээс дээш этгээд хамтран байгуулж байгаа бол хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ;

6.3.3.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм болон түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар;

6.3.4.гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтыг нотлох дараах баримт бичиг:

6.3.4.1.мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх тохиолдолд гадаад улсаас мөнгөн хөрөнгө шилжүүлснийг нотолсон банкны тодорхойлолт, дансны хуулгын хамт;

6.3.4.2.бэлэн мөнгөөр хөрөнгө оруулалт хийх тохиолдолд дансны хуулга, шаардлага хангасан гаалийн мэдүүлэг, паспортын улсын хилээр нэвтэрсэн тэмдэглэгээтэй хуудасны хуулбар, эх үүсвэрийг нотлох баримт;

6.3.4.3.хөдлөх эд хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх тохиолдолд гаалийн мэдүүлэг, холбогдох нотлох баримт;

6.3.4.4.оюуны өмчөөр хөрөнгө оруулалт хийх тохиолдолд эрх бүхий байгууллагаас олгосон гэрчлэх баримт бичиг.

6.4.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл энэ журмын 6.2-т зааснаас гадна Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Нөхөрлөлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

Долоо.Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх

7.1.Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 19, 20, 21 дүгээр зүйлд заасныг баримтална.

7.2.Хуулийн этгээдийг нийлүүлэх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

7.2.1.нийлүүлэх, нэгтгэх тухай шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл;

7.2.2.нийлүүлэх, нэгтгэх тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасны дагуу өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт;

7.2.3.нийлүүлэх тохиолдолд шинээр байгуулсан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт, үйлчилгээний хөлс төлсөн баримт;

7.2.4.нэгтгэх гэрээ;

7.2.5.өөрчлөн байгуулсан хуулийн этгээдийн дүрэм;

7.2.6.өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан;

7.2.7.санг өөрчлөн байгуулах тохиолдолд Иргэний хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт заасны дагуу эд хөрөнгийг шилжүүлсэн тухай холбогдох байгууллагын шийдвэр;

7.2.8.улсын бүртгэлийн гэрчилгээ;

7.2.9.үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий этгээд гадаадын иргэн бол паспортын хуулбар;

7.2.10.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

7.2.11.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
7.2.12.хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт;
7.2.13.хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрөл.

7.3.Хуулийн этгээдийг хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

7.3.1.хуваах, тусгаарлах тухай шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл;
7.3.2.өөрчлөн байгуулсан хуулийн этгээдийн дүрэм;
7.3.3.өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан;
7.3.4.өөрчлөн байгуулсан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт, үйлчилгээний хөлс төлсөн баримт;

7.3.5.улсын бүртгэлийн гэрчилгээ;
7.3.6.үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий этгээд гадаадын иргэн бол паспортын хуулбар;

7.3.7.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;
7.3.8.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
7.3.9.хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт;
7.3.10.хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрөл.

7.4.Хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөгдсөнийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

7.4.1.хэлбэр өөрчилсөн тухай шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл;
7.4.2.хуулийн этгээдийн дүрэм, хуульд заасан тохиолдолд гэрээ;
7.4.3.хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт, үйлчилгээний хөлс төлсөн баримт;

7.4.4.улсын бүртгэлийн гэрчилгээ;
7.4.5.үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий этгээд гадаадын иргэн бол паспортын хуулбар;

7.4.6.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;
7.4.7.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
7.4.8.хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрөл.

Найм.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн улсын бүртгэл хөтлөх

8.1.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасныг баримтална.

8.2.Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ:

8.2.1.хуулийн этгээдийн нэр, төрөл, хэлбэр;
8.2.2.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч;
8.2.3.хувь нийлүүлсэн хөрөнгө;
8.2.4.хувьцаа эзэмшигчийн хувь;
8.2.5.төлөөлөн удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий этгээд;

8.2.6.хаяг;
8.2.7.үйл ажиллагааны чиглэл;
8.2.8.үйл ажиллагаа явуулах хугацаа;
8.2.9.дүрэм, гэрээ;
8.2.10.салбар, төлөөлөгчийн газар, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлт;

8.2.11.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл.

8.3.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

8.3.1.хуулийн этгээдийн нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт, өдөр тутмын сонинд зарлуулсан зар /энэ заалт төрийн байгууллагад хамаарахгүй/;

8.3.2.үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, эрх бүхий этгээдийн шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл;

8.3.3.дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, хуульд заасан тохиолдолд гэрээний нэмэлт, өөрчлөлт, эсхүл шинэчилсэн дүрэм /гэрээ/;

8.3.4.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, удирдах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөл, эрх бүхий этгээдийг бүртгүүлэх тохиолдолд тэдгээрийг сонгосон, өөрчилсөн тухай үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн шийдвэр/тогтоол/, хурлын тэмдэглэл;

8.3.5.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий этгээд гадаадын иргэн бол паспортын хуулбар;

8.3.6.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, эрх бүхий этгээд хуралд оролцоогүй тохиолдолд хурлын зар хүргэсэн талаарх нотлох баримт;

8.3.7.эрх шилжүүлэх тохиолдолд Иргэний хуульд заасан нотариатаар гэрчлүүлсэн холбогдох гэрээ, эсхүл өв залгамжлах эрхийн гэрчилгээ;

8.3.8.хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах тохиолдолд баталгаажсан санхүүгийн тайлан;

8.3.9.хаяг өөрчлөгдөх тохиолдолд хаягийн нотлох баримт;

8.3.10.улсын бүртгэлийн гэрчилгээ;

8.3.11.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

8.3.12.үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг бүртгүүлэх тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрчилгээ;

8.3.13.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд холбогдох татвар төлсөн талаарх татварын албаны тодорхойлолт;

8.3.14.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

8.3.15.хууль, журамд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрөл.

8.4.Өргөдөл гаргагч энэ журмын 8.1-д заасан хугацаанд баримт бичгээ ирүүлсэн боловч улсын бүртгэгч энэ журмын 11-д зааснаар улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан бол хуулийн хугацаанд баримт бичгийг ирүүлсэнд тооцно.

Ес.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн улсын бүртгэл хөтлөх

9.1.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасныг баримтална.

9.2.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

9.2.1.улсын бүртгэлийн гэрчилгээ;

9.2.2.үүсгэн байгуулагч нь гадаадын хуулийн этгээд бол дүрмийн хуулбар;

9.2.3.үүсгэн байгуулах эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/;

9.2.4.салбар, төлөөлөгчийн газрын ажиллах журам;

9.2.5.гүйцэтгэх удирдлага гадаадын иргэн бол паспортын хуулбар;

9.2.6.хаягийн нотлох баримт;

9.2.7.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

9.2.8.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

9.2.9.хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрөл.

9.3.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

9.3.1.өөрчлөлт оруулах тухай үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/;

9.3.2.гүйцэтгэх удирдлага гадаадын иргэн бол паспортын хуулбар;

9.3.3.хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээ;

9.3.4.хаяг, холбогдох өөрчлөлтийн нотлох баримт;

- 9.3.5.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;
- 9.3.6.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
- 9.3.7.хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрөл.

9.4.Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах хугацааг сунгахад дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

- 9.4.1.эрх бүхий этгээдийн шийдвэр;
- 9.4.2.улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 9.4.3.татварын байгууллагын тодорхойлолт;
- 9.4.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

Арав.Улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгох улсын бүртгэл хөтлөх

10.1.Хуулийн этгээдэд улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгоход Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийн 8.8.1, 8.8.3, 8.8.4, 8.8.5, 8.8.6 -д заасныг баримтална.

10.2.Хуулийн этгээдэд улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгоход дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

- 10.2.1.эрх бүхий этгээдийн шийдвэр /тогтоол/;
- 10.2.2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.1, 8.8.3-т заасан тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 10.2.3.хууль хяналтын байгууллагын шийдвэр;
- 10.2.4.улсын бүртгэлийн гэрчилгээ үрэгдүүлсэн бол өдөр тутмын сонинд зарлуулсан зар;
- 10.2.5.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

Арван нэг.Хуулийн этгээдийг татан буулгасны улсын бүртгэл хөтлөх

11.1.Хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23, 24, 25 дугаар зүйлд заасныг баримтална.

11.2.Хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргасан эрх бүхий этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад бичгээр мэдэгдэж, шийдвэрийн эх хувийг мэдэгдэлд хавсаргана.

11.3.Хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэхэд татан буулгах комисс, эсхүл эрх хүлээн авагч нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дараа дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргаж, улсын бүртгэлийн байгууллагад ирүүлнэ:

- 11.3.1.татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/;
- 11.3.2.дуусгалтын тайлан;
- 11.3.3.татвар төлөгчийн хасалтын карт;

11.3.4.өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа;

11.3.5.татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар;

11.3.6.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

11.3.7.тамга, тэмдэг хураалгасан баримт;

11.3.8.улсын бүртгэлийн гэрчилгээ, хэрэв үрэгдүүлсэн бол өдөр тутмын сонинд зарлуулсан зар;

11.3.9.хуульд заасан бусад.

11.4.Улсын бүртгэгч энэ журмын 11.3-т заасан өргөдөл, баримт бичгийг ажлын 3 өдрийн дотор хянаж, татан буулгасныг улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулж, тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасна.

11.5.Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.5 дахь заалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасна.

11.6.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг зогсоосныг улсын бүртгэлд бүртгэхэд үүсгэн байгуулагч хуулийн этгээдийн шийдвэр /тогтоол/, эсхүл шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

Арван хоёр.Улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах

12.1.Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзахад Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасныг баримтална.

12.2.Улсын бүртгэгч дараах тохиолдолд хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан шийдвэрийг бичгээр гаргаж, өргөдөл гаргагчаас ирүүлсэн баримт бичгийн хамт энэ журмын 2.4-т заасан этгээдэд шилжүүлнэ:

12.2.1.улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл, баримт бичиг нотлох баримтын шаардлага хангаагүй, бүрдэл дутуу бол;

12.2.2.энэ журмын 3.1-д заасан өргөдөл гаргах этгээдээс бусад этгээд өргөдөл гаргасан бол;

12.2.3.энэ журмын 5.2.2, 5.2.3-д заасны дагуу хүчингүй болгосон, хориг тавьсан /түдгэлзүүлсэн/ үндэслэл арилаагүй бол;

12.2.4.өргөдөл гаргагч хуульд заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн бол.

12.3.Улсын бүртгэгч энэ журмын 12.2-т заасан татгалзсан шийдвэрийг тухайн хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргана.

Арван гурав.Улсын бүртгэлд хориг тавих /түдгэлзүүлэх/, цуцлах

13.1.Эрх бүхий байгууллагын шийдвэр, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн улсын бүртгэлийг түдгэлзүүлнэ.

13.2.Энэ журмын 13.1-т заасан үндэслэлээр улсын бүртгэлийг түдгэлзүүлсэн тохиолдолд улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэж, шийдвэр, дүгнэлт, албан бичгийг тухайн хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргана.

13.3.Энэ журмын 13.1-т заасны дагуу түдгэлзүүлснийг эрх бүхий этгээдийн шийдвэр, дүгнэлтийг үндэслэн цуцална.

Арван дөрөв.Бусад

14.1.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон этгээд шүүхээс гардан авсан нэхэмжлэл, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон тухай шийдвэр, шүүхэд өгсөн хариу тайлбар зэрэг нотлох баримт, шүүхийн шийдвэрийг холбогдох хувийн хэрэгт хавсаргана.

---oOo---